<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>513,033.80</b>	<b>419,406.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	513,033.80	419,406.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,425,806.10</b>	<b>1,426,187.39</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,425,806.10	1,394,277.77
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	31,909.62
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>914,938.55</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>2,127,466.41</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>198</b>	<b>198</b>
610001	Төсвийн байгууллага	191	191
610002	Төсвөөс гадуур байгууллага	7	7

<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	5,260	5,502
620001	Удирдах ажилтан	295	295
620002	Гүйцэтгэх ажилтан	3,011	3,159
620003	Үйлчлэх ажилтан	1,649	1,761
620004	Гэрээт ажилтан	305	287
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	31,600	31,998
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	24,864	24,350
630001	Төрийн өмчит ЕБС	24,587	24,073
630002	Хувийн ЕБС	277	277
<b>631</b>	<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	6,736	7,648
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	6,736	7,648
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага		
<b>632</b>	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>	-	-
632001	Төрийн өмчит МСҮТ		
632002	Хувийн МСҮТ		
<b>64</b>	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	-	17,333
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо		1,297
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо		16,036
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо		
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>5,260</b>	<b>5,502</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	259	255
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	3	3
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	2,249	2,481
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	21	21
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	150	152
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	349	353
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1,838	1,839
650010	Гэрээт ажилтан	261	264
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	130	134

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,426,927.2</b>	<b>3,096,100.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,384,725.6</b>	<b>2,923,315.0</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	3,301,643.2	2,282,185.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	114,183.4	618,996.3
210101	Үндсэн цалин	112,298.4	535,227.9
210102	Нэмэгдэл	-	645.3
210104	Урамшуулал	1,885.0	83,123.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,733.7	68,103.3
210201	Тэтгэврийн даатгал	56,733.7	67,451.3
210202	Тэтгэмжийн даатгал	-	652.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,450.8	39,663.3
210301	Гэрэл, цахилгаан	1,684.8	7,762.6
210302	Түлш, халаалт	3,766.0	31,698.7
210303	Цэвэр, бохир ус	-	202.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	104,544.3	173,034.5
210401	Бичиг хэрэг	2,144.7	28,354.7
210402	Тээвэр, шатахуун	45,707.8	89,850.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,161.6	4,028.1
210404	Ном, хэвлэл	3,446.1	245.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	39,878.1	20,669.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,206.0	29,887.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	184,720.1	253,210.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	171,211.0	226,941.1
210502	Хоол, хүнс	4,623.7	18,458.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,885.4	7,811.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	58,738.9	63,784.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	42,234.6	32,444.3
210602	Тавилга	5,000.0	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100.0	-
210604	Урсгал засвар	11,404.3	31,339.7
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,991.8	16,387.7
210702	Дотоод албан томилолт	2,991.8	16,387.7
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,091.7	22,246.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,026.5	20,896.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,250.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5.2	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,766,188.7	1,026,759.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,739,318.8	905,696.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,869.9	121,062.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,760.0	569,111.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,760.0	569,111.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	367,000.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760.0	202,111.0

<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>77,322.4</b>	<b>72,018.1</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,005.5
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	77,322.4	9.4
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	71,003.2
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>42,201.6</b>	<b>172,785.4</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	42,201.6	172,785.4
220001	Барилга байгууламж		
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,201.6	172,785.4
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,396,347.7</b>	<b>3,088,184.0</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,396,347.7</b>	<b>3,088,184.0</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	307,357.9	93,892.5
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,803.8	42,600.2
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,850,092.4	2,372,024.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	197,093.6	579,667.0
131106	Төсвийн урамшуулал	-	-
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(30,579.6)</b>	<b>(7,916.4)</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,953.7	12,374.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,374.1	4,457.7

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Д.Бауыржан танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилт, ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан “Жана өлке” ОНӨААТҮГ-ын өр төлбөртэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, аудитор Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 2-01/377 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, цахим шинэчлэлийг хэрэгжүүлсэн байгууллага болох” гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэн гаргаж ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Засаг даргын дэргэд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Санхүүгийн хяналт, аудитын алба ажиллаж байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2021 онд нийт 129 нэгжид хяналт, шалгалт хийж, давхардсан тоогоор 263 нэгжийг хамруулжээ. Үүнээс төлөвлөгөөт 129, Сангийн сайдын удирдамжаар 3, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр болон иргэдийн өргөдөл гомдлоор 30 шалгалт хийж, дүгнэлт гаргасан байна.

Хяналт шалгалтаар нийтдээ 104.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 18.7 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч биелэлтийг хангуулж, 85.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Актын дүнгээр орон нутгийн төсөвт 46.9 сая төгрөг оруулж, 33.3 сая төгрөгийг тухайн байгууллагад, 5.5 сая төгрөгийг хувь хүнд эргүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Тайлант онд өмнөх онд төлөгдөөгүй актаас 10.0 сая төгрөг, тайлант оны актаас 40.1 сая төгрөг, бүгд 50.1 сая төгрөгийг төлбөрийг барагдуулсан байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймаг, сумын төрийн сан, Санхүүгийн албаны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод хяналтыг өдөр тутмын хяналт, төлөвлөгөөт хяналт, төлөвлөгөөт бус хяналт гэсэн хэлбэрээр явуулж ирсэн байна.

Өдөр тутмын хяналтаар Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн системээр дамжуулан төрийн санд харьяалах төсөвт байгууллагуудын орлого, зарлагын хуулгыг өдөр бүр шалган буцсан гүйлгээ болон орлого бууруулах гүйлгээг хянаж, илэрсэн зөрчлийг холбогдох сумуудын Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, төлбөр тооцооны мэргэжилтнүүдэд зөвлөгөө өгч тухай бүр арилгуулан ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Улсын төсвөөс санхүүжидэг байсан Дэлүүн, Ногооннуур, Цэнгэл сумын Сум дундын эмнэлэг нь бүтцийн өөрчлөлтөөр 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалалд шилжиж, сумын Эрүүл мэндийн төв болж өөрчлөгдөн, Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд орсон байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 101423.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1014.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 608.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3195.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8608.7 сая төгрөг болж, оны эхнээс 5413.7 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №01 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>
<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>Өсөлт (+), Бууралт (-)</b>
Касст байгаа бэлэн мөнгө	7.7	5.3	(2.4)
Банканд байгаа бэлэн мөнгө	3,187.3	8,603.4	5,416.1
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
<b>Дүн</b>	<b>3,195.0</b>	<b>8,608.7</b>	<b>5,413.7</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	943.5	1,862.9	919.4
Төсөл/ сан	222.6	4,276.3	4053.7
Төрийн сан	1,544.0	1,716.2	172.2
ТӨҮГ болон ОНӨҮГ	484.9	753.3	268.4
<b>Дүн</b>	<b>3,195.0</b>	<b>8,608.7</b>	<b>5,413.7</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Оны эхний мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 7.7 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 3187.3 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна.

Оны эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 5.3 сая төгрөг нь кассад байгаа бэлэн мөнгө, 8603.4 сая төгрөг нь банкинд байгаа бэлэн мөнгө байна.

Банкинд байршиж буй 8603.4 сая төгрөгт гадаад валютаар байршсан мөнгөн хөрөнгө байхгүй байна. Банкинд байгаа 8603.4 сая төгрөгийн 7776.3 сая төгрөг нь төрийн сангийн үлдэгдэл, 827.1 сая төгрөг нь арилжааны банкны үлдэгдэл байна. Үүнээс 1862.9 сая төгрөг нь төсөвт байгууллагын, 4276.3 сая төгрөг нь төсөл сангийн, 1716.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, 753.3 сая төгрөг нь ОНӨҮГ-уудын дансны үлдэгдэл байна.

#### Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн харилцахын эхний үлдэгдэл 2654.3 сая төгрөг байснаас 5121.9 сая төгрөгөөр өсөж оны эцэст 7776.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт №02 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө			
Төгрөг			
Нэмэлт санхүүжилт			
Банканд байгаа мөнгөн хөрөнгө			
Төгрөг			
Төрийн сан	2654.3	7776.2	5,121.9
Арилжааны банкин дахь харилцах			
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.2	0.1	-0.07
Нэмэлт санхүүжилтийн ажилжааны банк			
<b>Нийт дүн</b>	<b>2654.5</b>	<b>7776.3</b>	<b>5,121.8</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдэл 2654.3 сая төгрөгөөс тайлант онд 1595.5 сая төгрөгийг орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэхэд, 1058.8 сая төгрөгийг он дамжин хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 7776.3 сая төгрөгийг задалбал: 1696.5 сая төгрөг нь орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны, 1196.8 сая төгрөг нь ОНХС-ийн, 857.6 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 70.6 сая төгрөг нь Замын сангийн, 3807.1 сая төгрөг нь Хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл, 78.5 сая төгрөг нь нэмэлт санхүүжилтээс татан төвлөрүүлсэн мөнгө, 45.2 сая төгрөг нь сумдын БОХНСТС барьцаа дансны үлдэгдэл, 24.0 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын дансны үлдэгдэл байна.

#### Аудитын илрүүлэлт:

Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Толбо сумын Засаг даргын тамгын газар 18.0 сая төгрөгийн, Өлгий сумын ЗДТГ 1.8 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлээгүй дансны үлдэгдлээр тайлагнасан, Бугат сумын Эрүүл мэндийн төвд батлагдсан төсвөөс 2.5 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон зөрчлүүдэд төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.

Буянт сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Сум хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг 30.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж ирүүлснийг залруулсан.

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар богино хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 6779.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 6331.9 сая төгрөг болж, оны эхнээс 447.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №03 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	265.8	68.4	-197.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	92.7	723.1	630.4
Татаас, санхүүжилтийн авлага	7.0		-7.0
Зээлийн хүүгийн авлага	9.6	17.2	7.0
Дансны авлага /ТӨҮГ/	6.5	6.5	-

Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.1	0.1	-
Бусад авлага	1990.1	1793.8	-196.3
Зээлийн авлага	4407.6	3722.8	-684.8
<b>Дүн</b>	<b>6,779.4</b>	<b>6,331.9</b>	<b>-447.5</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	393.3	891.1	497.8
Төсөл/ сан	4177.6	3496.1	-681.5
Төрийн сан	256.8	256.8	-
ОНӨҮГ	1951.7	1687.9	-263.8
<b>Дүн</b>	<b>6,779.4</b>	<b>6,331.9</b>	<b>-447.5</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын үлдэгдлийн 14.1 хувийг төсөвт байгууллагын, 55.2 хувийг төсөл сангийн, 4.0 хувийг төрийн сангийн, 26.7 хувийг аж ахуйн нэгжүүдийн авлага эзэлж байна.

Төсөл сангуудын авлага 681.5 сая төгрөгөөр, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн авлага 263.8 сая төгрөгөөр тус тус буурч, төсөвт байгууллагын авлага 497.8 төгрөгөөр өссөн байна. Төрийн сангийн авлагын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Төсөл сангуудаас Бугат сумын ОНХС 0.3 сая, Өлгий сумын ОНХС 4.0 сая төгрөгөөр авлагаа бууруулж, Дэлүүн сумын ОНХС-гийн 5.1 сая, БОХС-гийн 1.4 сая төгрөгийн авлага барагдаагүй,

СХСангуудаас Алтай сум 49.6 сая, Баяннуур 59.8 сая, Булган 35.3 сая, Буянт 102.8 сая, Дэлүүн 12.9 сая, Ногооннуур 21.3 сая, Сагсай 52.9 сая, Толбо 29.7 сая, Цэнгэл 9.4 сая, Өлгий сум 332.3 сая төгрөгөөр буюу нийтдээ 706.0 сая төгрөгөөр авлагаа бууруулж, Алтанцөгц сум 3.0 сая, Бугат сум 6.2 сая, Улаанхус сум 19.6 сая төгрөгөөр буюу нийтдээ 28.8 сая төгрөгөөр авлага нь нэмэгдсэн байна.

Тайлант онд Алтай, Баяннуур, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Цэнгэл, Өлгий сумуудын СХС-гаас нэмж зээл олгоогүй, Алтанцөгц 72.9 сая, Бугат 40.2 сая, Булган 93.0 сая, Сагсай 64.9 сая, Улаанхус 19.6 сая, нийтдээ 290.6 сая төгрөгийн зээлийг зээлийн эргэн төлөлтийн орлогоос олгосон байна.

Төрийн сангийн авлагын дансны үлдэгдэлд Дэлүүн сумын Орон нутгийн ерөнхий орлогын 3.0 сая, Баяннуур сумын Орон нутгийн ерөнхий орлогын 3.4 сая, аймгийн Орон нутгийн ерөнхий орлогын 250.4 сая төгрөгийн он дамжсан авлагууд барагдаагүй, үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна

Төсөвт байгууллагуудын авлагын үлдэгдэл өмнөх оноос 497.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд сумын Эрүүл мэндийн төвүүд Алтай сум 38.3 сая, Алтанцөгц 73.8 сая, Баяннуур 26.6 сая, Бугат 6.6 сая, Буянт 42.3 сая, Ногооннуур 41.7 сая, Толбо 33.5 сая, Сагсай 18.2 сая, Улаанхус 46.4 сая, Цэнгэл 58.9 сая, Цагааннуур 1.5 сая, Өрхийн эрүүл мэндийн төв 42.9 сая, нийтдээ 429.4 сая төгрөгийн ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага шинээр бүртгэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/1075 тоот захирамжаар БШУС-ын 2021 оны 1а/6368 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг үндэслэн сургууль, цэцэрлэгүүдийн сургалт, үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой 2021 оны батлагдсан төсвөөс гарсан хэмнэлтээс 330.0 сая төгрөгийг “Багшийн хөгжлийн танхим” ажиллуулахаар баталж Өлгий сумын Ерөнхий боловсролын 5, 7 дугаар сургууль, Алтай, Алтанцөгц, Бугат, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Цагааннуур тосгон, Цэнгэл, Өлгий сумын хүүхдийн цэцэрлэг, бүгд 22 байгууллагын төсөвт тус бүр 15.0 сая төгрөгийн зохицуулалт хийж нийтдээ 329.8 сая төгрөгийг тухайн байгууллагууд оны эцэст гэрээний дагуу шилжүүлж, шинээр авлагаар бүртгэсэн байна.

Мөн үүнээс гадна Аймгийн ИТХ, Баяннуур, Булган сумын ИТХ, Буянт, Улаанхус сумын ЗДТГ 0.1-2.3 сая төгрөгөөр, Булган сумын ЕБ-ийн 1-р, Сагсай сумын ЕБ-ын 1-р, Өлгий сумын ЕБ-ын 6-р сургууль, Буянт, Цэнгэл сумын 4-р хүүхдийн цэцэрлэгүүд 0.5-3.3

сая төгрөгөөр, Булган, Улаанхус сумын Соёлын төвүүд 0.9 сая төгрөгөөр шинээр авлага үүсгэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэлд шууд нэгтгэгддэг байгууллагуудаас Орон нутгийн өмчийн газар, Биеийн тамир спортын газар, Хөгжимт драмын театр, Насан туршийн боловсролын төв өмнөх оны 24.0 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, Асрамжийн газар, ГХБХБГ, Ахмадын сан 0.1-4.4 сая төгрөгөөр авлагаа бууруулсан байна.

ОНӨҮГ-уудын авлага өмнөх оноос 263.8 сая төгрөгөөр буурчээ. ЦСШГ-ын авлага 399.7 сая, “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын авлага 3.8 сая, Алтанцөгц сумын ЭЭС-гийн авлага 3.5 сая, нийтдээ 407.0 сая төгрөгөөр буурч, “Суат” ХХК-ний авлага өмнөх оноос 69.6 сая, “Өлгий Сансар” эмнэлгийн авлага 55.0 сая, Алтай сумын ЭЭС 2.5 сая, Алтанцөгц сумын ЭЭС 11.0 сая, Булган сумын ЭЭС 0.2 сая, Ногооннуур сумын ЭЭС 2.0 сая, Сагсай сумын ЭЭС 2.9 сая, нийтдээ 143.2 сая төгрөгийн авлага шинээр нэмэгдсэн байна.

“Суат” ХХК жилийн эцэст төр хариуцах цэвэр, бохир усны төлбөрийн авлага, “Өлгий Сансар” эмнэлэгийн ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага шинээр бүртгэгдсэнтэй холбоотой авлага нэмэгдсэн байна.

Цахилгаан шугам сүлжээний газарт 2009-2010 онуудад үүссэн олон жил болсон байгууллага, хувь хүмүүсээс авах барагдах боломжгүй 87.1 сая төгрөгийн авлага байгаагаас 45.6 сая төгрөг нь шүүхийн тогтоол гарч найдваргүй авлагад бүртгэгдсэн байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар авлагатай холбоотой дараах алдаа зөрчил илэрсэн байна. Үүнд:*

- Толбо сумын ОНХС-гаас “Толбо сумын өвс тэжээлийн нөөцөд боодолтой өвс нийлүүлэх” гэрээний дагуу 16.0 сая төгрөг, “Арьс ширний цех барих, тоног төхөөрөмж нийлүүлэх” гэрээний дагуу 16.0 сая төгрөг шилжүүлсэн боловч гэрээний хугацаа дууссан ч ажлыг хүлээж аваагүй, мөн гэрээгүй зөвхөн нэхэмжлэлээр “Толбо сумын төвийн 2.31 км авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам, сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын үнэ”-д 10.0 сая төгрөг шилжүүлэн санхүүгийн тайланд авлагаар тусгаж харуулаагүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.*
- Алтанцөгц сумын Хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайлангаар Аймгийн Засаг даргын 2021 оны А/1075 тоот захирамжаар төсөвт хийсэн зохицуулалтаар эд хогшил, урсгал засварын зардалд багаж, техник, хэрэгсэл авах 15.0 сая төгрөгийг гүйцэтгэгч компанид шилжүүлэн хөрөнгийг орлого авч бүртгэснийг авлагад тусгуулан залруулав.*
- Цэнгэл сумын Сум хөгжүүлэх сан жилийн эцсийн 363.3 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлийг баталгаажуулаагүй, тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс дансанд 139.0 сая төгрөг орсон боловч зээлийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлээс 167.6 сая төгрөг төлөгдсөнөөр хасалт хийж, зээлийн программ дахь үлдэгдлийг 28.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.*
- Булган сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар СХС-гийн тайланд 62.3 сая төгрөгийн авлагын залруулга хийгдсэн.*

### **3.5.4 Урьдчилгаа**

Урьдчилгаа дансны оны эхний үлдэгдэл 13.4 сая, эцсийн үлдэгдэл 12.1 сая төгрөг

болж, оны эхнээс 1.1 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №04 Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	13.4	12.3	-1.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
<b>Дүн</b>	<b>13.4</b>	<b>12.3</b>	<b>-1.1</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	13.4	12.3	-1.1
<b>Дүн</b>	<b>13.4</b>	<b>12.3</b>	<b>-1.1</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

“Суат” ХХК урьдчилгаа дансанд 2016 онд 13.4 сая төгрөгийн төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн ба тайлант онд 1.1 сая төгрөгийг барагдуулж 12.3 сая төгрөгийн үлдэгдтэй гарчээ.

*Аудитын илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар урьдчилгаа данстай холбоотой зөрчил гараагүй байна.*

### 3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд үлдэгдэлгүй байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 5140.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5849.7 сая төгрөг болж, оны эхнээс 709.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №05 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>5128.7</b>	<b>5791.9</b>	<b>663.3</b>
<b>Түүхий эд материал</b>	<b>311.5</b>	<b>456.7</b>	<b>145.2</b>
Тусгай зориулалттай материал	133.1	150.6	17.5
Эм боох материал	178.4	306.1	127.7
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>18.1</b>	<b>45.5</b>	<b>27.4</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>4588.4</b>	<b>5095.6</b>	<b>507.2</b>
Бичиг хэргийн материал	86.7	86.3	-0.3
Аж ахуйн материал	2226.2	2432.2	206.0
Сэлбэг хэрэгсэл	127.3	236.2	109.0
Түлш, шатах тослох материал	182.0	126.0	-55.9
Барилгын засварын материал	11.4	6.0	-5.4
Хүнсний материал	656.0	712.5	56.5
Бусад хангамжийн материал	1298.8	1496.3	197.4
<b>Мал амьтад</b>	<b>210.7</b>	<b>194.1</b>	<b>-16.6</b>
Нөөцийн бараа	12.1	57.8	45.7
<b>Дүн</b>	<b>5140.7</b>	<b>5849.7</b>	<b>709.0</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4850.5	5405.0	554.5
Төсөл/ сан			
Төрийн сан			
ОНӨҮГ	290.2	444.7	154.5

<b>Дүн</b>	<b>5140.7</b>	<b>5849.7</b>	<b>709.0</b>
------------	---------------	---------------	--------------

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт бараа материалын үлдэгдлийн 92.3 хувийг буюу 5405.0 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын, 7.7 хувийг буюу 444.7 сая төгрөгийг орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн бараа материалын үлдэгдэл эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8600.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 914.3 сая төгрөгийн материал хүлээн авч, 8348.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 457.1 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Үүнээс төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр 7210.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 750.9 сая төгрөгийн бараа материал, бүтцийн өөрчлөлтөөр 78.3 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, 7107.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 422.6 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд 1386.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар болон шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээс 30.2 сая төгрөгийн материал хүлээн авч, 1239.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 22.4 сая төгрөгийн бараа материалыг шилжүүлж, данснаас хасжээ.

Төсөвт байгууллагууд оны эцэст 107.2 сая төгрөгийн тусгай зориулалтын, 229.5 сая төгрөгийн эм боох, 85.5 сая төгрөгийн бичиг хэргийн, 2351.0 сая төгрөгийн аж ахуйн, 7.1 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийн, 123.3 сая төгрөгийн түлш шатах тослох, 6.0 сая төгрөгийн барилгын, 708.7 сая төгрөгийн хүнсний, 1489.3 сая төгрөгийн бусад хангамжийн материалын, 45.5 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүний, 194.1 сая төгрөгийн мал амьтад, 57.8 сая төгрөгийн нөөцийн барааны үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд оны эцэст 444.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй бөгөөд үүний 43.4 сая төгрөг нь тусгай зориулалтын, 76.5 сая төгрөг нь эм боох, 0.9 сая төгрөг нь бичиг хэргийн, 81.2 сая төгрөг нь аж ахуйн, 229.1 сая төгрөг нь сэлбэг хэрэгсэл, 2.7 сая төгрөг нь түлш, шатах тослох, 3.9 сая төгрөг нь хүнсний, 7.0 сая төгрөг нь бусад хангамжийн материал байна.

Төсвийн захирагчдын ангиллаар авч үзвэл Алтай сум 332.7 сая төгрөгийн, Алтанцөгц сум 176.8 сая төгрөгийн, Баяннуур сум 270.1 сая төгрөгийн, Бугат сум 158.4 сая төгрөгийн, Булган сум 369.1 сая төгрөгийн, Буянт сум 102.8 сая төгрөгийн, Дэлүүн сум 385.3 сая төгрөгийн, Ногооннуур сум 501.8 сая төгрөгийн, Сагсай сум 326.9 сая төгрөгийн, Толбо сум 286.1 сая төгрөгийн, Улаанхус сум 611.0 сая төгрөгийн Цагааннуур тосгон 107.2 сая төгрөгийн, Цэнгэл сум 249.2 сая төгрөгийн, Өлгий сум 1100.4 сая төгрөгийн, бусад байгууллагууд 813.9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Зарим байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 17.6-206.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийт бараа материалын үлдэгдлийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Төсөвт байгууллагуудын бараа материалын үлдэгдэл оны эхнээс 554.5 сая төгрөгөөр өссөн байна. Аж ахуйн материал 206.0 сая төгрөгөөр, бусад хангамжийн материал 197.4 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 109.0 сая төгрөгөөр, хүнсний материал 56.5 сая төгрөгөөр, эм боох материал 127.7 сая төгрөгөөр, тусгай зориулалтын материал 17.5 сая төгрөгөөр, нөөцийн бараа 45.7 сая төгрөгөөр нэмэгдэж, түлш шатлах тослох материал 55.9 сая төгрөгөөр, мал амьтад 16.6 сая төгрөгөөр, барилгын засварын материал 5.4 сая төгрөгөөр, тусгай зориулалтын материал 2.0 сая төгрөгөөр буурсан байна.

*Аудитын илрүүлэлт: ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангаар бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:*

- Сагсай сумын Эрүүл мэндийн төв нь жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын эхний үлдэгдэл няравын материалын тайлангийн үлдэгдлээс 22.8 сая төгрөгөөр, эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөгөөр, жилийн эцсийн тооллогын дүнгээс 26.9 сая төгрөгөөр зөрүүтэй, 15.6 сая төгрөгийн эмийн тооллогын баримтыг аудитад ирүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, нягтлан бодох бүртгэлийн заавал хөтлөх журнал, дэлгэрэнгүй болон ерөнхий данс бүртгэлийг хөтлөөгүй байна.
- Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд 114.7 сая төгрөгийн, Бугат сумын Ерөнхий боловсролын сургуульд 116.0 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвд 9.0 сая төгрөгийн, Булган сумын Засаг даргын тамгын газарт 62.8 сая төгрөгийн, Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд 14.6 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвд 50.2 сая төгрөгийн, Толбо сумын хүүхдийн цэцэрлэгт 15.5 сая төгрөгийн, Өлгий сумын ЗДТГ-т 10.7 сая төгрөгийн, Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгт 12.8 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийн тооллого хийгдээгүй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.
- Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 7.8 сая төгрөгийн аж ахуй, хүнсний материал дутсаныг санхүүгийн тайланд үлдэгдлээр тайлагнаж ирүүлсэн.
- Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлээр 7.9 сая төгрөгийн хүнсний материал тоологдсон боловч санхүүгийн тайланд 12.8 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаар тусгаж, үлдэгдлийг 4.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан.
- Сагсай сумын Засаг даргын тамгын газар малжуулах төслийн хүрээнд иргэдэд олгосон бодитоор байхгүй 23.5 сая төгрөгийн малыг бараа материалын дансанд бүртгэсэн байна.
- Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нормативт зардлын гүйцэтгэлд хүүхэд-өдрөөр хяналт тавьж, хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлж ажиллаагүйгээс оны эцэст үдийн хоолны зардлаар 22.7 сая төгрөгийн хүнсний зүйл нөөцөлж төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн, Алтай сумын 1 дүгээр сургууль, Баяннуур сумын 2 дугаар сургууль, Ногооннуур сумын 2 дугаар сургууль, Улаанхус сумын 2 дугаар сургууль дотуур байрны хүүхдийн хоолонд Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормыг 3.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсныг нөхөн төлүүлэхээр тус тус төлбөрийн акт тогтоосон.
- Алтай сумын Эрүүл мэндийн төв 4.1 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сан 5.6 сая төгрөгийн эмийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор акталж данснаас хассан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Өлгий сумын ЗДТГ, Цагааннуур тосгоны Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Сагсай сумын 1 дүгээр сургууль, Баяннуур сумын 2 дугаар сургууль, Ногооннуур сумын 3 дугаар сургууль, Дэлүүн сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг зэрэг байгууллагууд няравын бараа материалын тайланг гаргуулж тооцоо хийгээгүй, санхүүгийн тайлангаарх бараа материалын орлого, зарлага, үлдэгдлийг няравын бараа материалын тайлангийн орлого, зарлага, үлдэгдлээс зөрүүтэй тайлагнасан, шатахууны зарцуулалтын тооцоо хийгдээгүй, зарлагын анхан шатны баримтуудыг дутуу бүрдүүлсэн байна.
- Толбо сумын хүүхдийн цэцэрлэг 2.7 сая төгрөгийн, Өлгий сумын 5 дугаар хүүхдийн цэцэрлэг 2.9 сая төгрөгийн хүнсний чанар байдлаа алдсан материалыг мэргэжлийн хяналтын байгууллагын акт, дүгнэлтгүйгээр цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар акталж данснаас хассан байна.
- Улаанхус сумын Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний материалыг хэрэгцээнээс илүү

хэмжээгээр нөөцөлж бараа материалын үлдэгдлийг их хэмжээгээр нэмэгдүүлсэн. Энэ нь төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэн нөгөө талаар сумын санхүү, төрийн сангаас норматив зардлын төсвийн зарцуулалтад хүүхэд өдрийн гүйцэтгэлээр хяналт тавьж ажиллаагүй, хяналт хангалтгүй хийгдсэнтэй холбоотой, өмнөх оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

- Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг өмнөх оны аудитаар хүнсний материалын тооллогоор илэрсэн 33.6 сая төгрөгийн зөрчлийн мөрөөр хүнсний материалын данснаас 29.0 сая төгрөгийн материалыг хасаж үүнээс 4.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд шилжүүлж, 22.3 сая төгрөгийг зардалд бичихдээ бүрдүүлсэн материалын үнэн зөвийг сумын санхүүгийн албаар хянаж баталгаажуулаагүй, бараа материал данснаас зарлага гаргах тухай тушаал шийдвэр гаргаж албажуулаагүй байна.
- Улаанхус сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 20.5 сая төгрөгийн, Хөххөтөл цэцэрлэг 16.7 сая төгрөгийн хүнсний бараа материал дансанд урьд жилүүдэд хоолны зардлын төсвөөс авсан материалыг бүртгэж ирснийг залруулж 23.9 сая төгрөгийг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн, 8.5 сая төгрөгийг зарцуулснаар данснаас хасахдаа тооцоо үнэн зөв эсэхийг сумын санхүүгийн албаар хянуулж баталгаажуулаагүй, бүрдүүлсэн баримтууд хангалтгүй байна.

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 214751.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 246179.3 сая төгрөг болж, 31427.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №06 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл		/сая төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж	132,583.3	141,268.3	8,685.0
Тээврийн хэрэгсэл	5,237.5	5,746.8	509.3
Машин тоног төхөөрөмж	30,158.0	32,824.7	2,666.7
Тавилга эд хогшил	6,735.1	7,167.6	432.5
Зам гүүрийн байгууламж	9,544.9	25,091.1	15,546.2
Түүх соёлын дурсгалт зүйл	1,584.8	1,603.5	18.7
Дуусаагүй барилга, байгууламж	1,371.1	4,567.0	3,195.9
Номын фонд	1,724.8	1,742.3	17.5
Бусад үндсэн хөрөнгө	15,891.4	15,926.4	35.0
Программ хангамж	129.4	148.2	18.8
Бусад биет бус хөрөнгө	9,791.1	10,093.4	302.3
<b>Дүн</b>	<b>214,751.4</b>	<b>246,179.3</b>	<b>31,427.9</b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	185,011.2	217,897.5	32,886.3
Төсөл/ сан			
Төрийн сан			
ТӨҮГ болон ОНӨҮГ	29,740.2	28,281.8	-1458.4
<b>Дүн</b>	<b>214,751.4</b>	<b>246,179.3</b>	<b>31,427.9</b>

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн тайлангаарх нийт үндсэн хөрөнгийн 88.5 хувийг төсөвт байгууллагын, 11.5 хувийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд нийт үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 946.7 сая төгрөгөөр, балансаас балансад шилжүүлэн авсан 2134.4 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хандиваар

авсан 34369.4 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 2937.6 сая төгрөгөөр, акталсан 3085.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансны оны эцсийн үлдэгдэлд 4567.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас Бугат сумд 23.0 сая төгрөгийн, Дэлүүн сумд 529.0 сая төгрөгийн, Өлгий сумд 3845.0 сая төгрөгийн, Асрамжийн газар 170.0 сая төгрөгийн дусаагүй барилга бүртгэлтэй байна.

Эдгээр дуусаагүй барилгаас Асрамжийн газрын 170.0 сая төгрөгийн дусаагүй барилга нь олон жил он дамжсан барилга, бусад нь улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 2022 онд ашиглалтад орох барилга, байгууламж байна. Тайлант онд үндсэн хөрөнгөд нийтдээ 8996.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

#### *Аудитын илрүүлэлт:*

*ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн тооллого, бүртгэл тооцоотой холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:*

- Алтай сумын Засаг даргын тамгын газар 39.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, Соёлын төв тооллого хийхдээ хөрөнгийн нэг бүрийн үнэ, нийт дүнгээр гаргаагүй дутуу тоолсон, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 327.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийн тооллого хийгдээгүй, хөрөнгийн үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.
- Бугат сумын Ерөнхий боловсролын сургууль 27.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, Эрүүл мэндийн төв 168.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогын дүнг гаргаагүй, хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, тооллоготой холбоотой өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан.
- Булган сумын Засаг даргын тамгын газрын 805.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй, хөрөнгийн үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.
- Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв 248.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг дутуу тоолсон, тооллогын бүртгэлийн дүн зөрүүтэй, хөрөнгийн үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар тооллогыг дутуу хийсэн зөрчлийг давтан гаргаж, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хөрөнгийн нэг бүрийн үнэ, нийт дүнгээр гаргаагүй, дутуу тоолсон.
- Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг 59.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг зохих журмаар хийгээгүй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.
- Сагсай сумын Эрүүл мэндийн төв жилийн эцсийн тооллогын бүртгэлийг баримтжуулаагүй, тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүй, үндсэн хөрөнгийн дүн, тооллогын дүнгээс 42.0 сая төгрөгөөр зөрүүтэй, өмнөх аудитаар хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, Засаг даргын тамгын газар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 27.6 сая төгрөгийн зам засварын ажлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.
- Толбо сумын Хүүхдийн цэцэрлэг жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохих ёсоор хийгээгүй, зарим хөрөнгийн дүн 21.5 сая төгрөгөөр зөрүүтэй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.
- Улаанхус сумын Хөх хөтөлийн цэцэрлэгийн жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн санхүүгийн тайлангийн үлдэгдлээс 86.5 сая төгрөгөөр зөрүүтэй, зарим хөрөнгийн үлдэгдлийг бүрэн тоолоогүй, үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй.

- Өлгий сумын ЗДТГазар жилийн эцсийн тооллогыг зохих журмаар хийж үлдэгдлийг баталгаажуулаагүйгээс үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн, санхүүгийн тайлан дахь дүнгээс 22.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.
- Хөгжимт драмын театр нь 2.4 сая төгрөгийн, Улаанхус сумын төвийн Хүүхдийн цэцэрлэг 59.7 сая төгрөгийн, Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 14.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан боловч Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргаагүй, устгал хийж баримтжуулаагүй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 5775.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5444.6 сая төгрөг болж, оны эхнээс 331.1 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
<i>Хүснэгт №07 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/</i>			
<b><u>Богино хугацаат өр төлбөр дүн</u></b>	<b>2490.0</b>	<b>2158.9</b>	<b>-331.1</b>
Өглөг	2223.9	1,892.8	-331.1
Урьдчилж орсон орлого	266.1	266.1	-
<b><u>Урт хугацаат өр төлбөр дүн</u></b>	<b>3285.7</b>	<b>3285.7</b>	<b>-</b>
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3127.7	3127.7	-
Хувь хүмүүсийн зээл	138.0	138.0	-
Санхүүгийн бусад байгууллага	20.0	20.0	-
<b><u>Нийт дүн</u></b>	<b><u>5,775.7</u></b>	<b><u>5,444.6</u></b>	<b><u>-331.1</u></b>
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	977.8	1225.9	248.1
Төсөл, сан	159.1	129.9	-29.2
Төрийн сан	4.9	4.9	-
ОНӨҮГ	4,633.9	4,083.9	-550.0
<b>ДҮН</b>	<b><u>5,775.7</u></b>	<b><u>5,444.6</u></b>	<b><u>-331.1</u></b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсөл сангуудын өглөг 18.3 хувиар, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өглөг 11.8 хувиар буурч, төсөвт байгууллагуудын өглөг 25.4 хувиар өсжээ.

#### Богино хугацаат өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр нийтдээ 1892.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс: 1225.9 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын, 129.9 сая төгрөг нь төсөл сангийн, 4.9 сая төгрөг нь төрийн сангийн, 532.1 сая төгрөг нь орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн өглөг байна.

Төсөл сангийн өглөг өмнөх оноос 29.2 сая төгрөгөөр буурсан нь Баяннуур сум 24.5 сая, Бугат 4.0 сая, Дэлүүн 3.8 сая, Сагсай 15.7 сая, нийтдээ 48.0 сая төгрөгөөр сумдууд ОНХС-гийн өглөгөө бууруулж, Алтай сум 0.9 сая, Алтанцөгц сум 5.4 сая, Булган сум 12.5 сая, нийт 18.8 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн. Төрийн сангийн өмнөх оны 4.9 сая төгрөгийн өглөг барагдаагүй байна.

ОНӨҮГ-ын өглөг оны эхнээс 550.0 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд ЦШСГазар 514.3 сая, “Суат” ХХК 53.5 сая, “Өлгий Сансар” эмнэлэг 0.5 сая, Цагааннуур тосгон ЭЭС

1.3 сая, нийт 569.6 сая төгрөгөөр өглөгөө бууруулж, “Хала-Өркени” ОНӨААТҮГ 8.5 сая, Алтай ЭЭС 2.5 сая, Алтанцөгц ЭЭС 8.6 сая, нийт 19.6 сая төгрөгөөр шинээр өглөгтэй гарчээ.

Төсөвт байгууллагуудын өглөг оны эхнээс 248.2 сая төгрөгөөр өссөн нь сумын ЭМТөвүүд ЭМД-ын сангаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбоотой өглөг нэмэгдсэн байна.

Алтай сумын ЭМТ 23.1 сая, Алтанцөгц сумын ЭМТ 30.0 сая, Баяннуур сумын ЭМТ 22.9 сая, Бугат сумын ЭМТ 2.3 сая, Булган сумын ЭМТ 44.5 сая, Буянт сумын ЭМТ 21.6 сая, Дэлүүн сумын ЭМТ 23.8, Сагсай сумын ЭМТ 0.8 сая, Улаанхус сумын ЭМТ 10.6 сая, Толбо сумын ЭМТ 4.1 сая, Цагааннуур тосгоны ЭМТ 19.1 сая, Цэнгэл сумын ЭМТ 87.0 сая, Хотгор ЭМТ 1.0 сая, Өрхийн эрүүл мэндийн төвүүд 52.8 сая төгрөгийн, нийтдээ 343.6 сая төгрөгийн өглөгтэй гарчээ. Үүнээс 23.1 сая төгрөгийн цалин хөлсний, 63.0 сая төгрөгийн НДШ-ийн, 25.0 сая төгрөгийн цалингийн татварын, 232.5 сая төгрөгийн бусад бараа үйлчилгээний зардлын өглөгтэй байна.

Бусад төсөвт байгууллагуудын өглөг буурсан үзүүлэлттэй, зарим он дамжсан, шинээр өглөг нэмэгдсэн шалтгааныг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд

- Орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлын санхүүжилт буюу түлш халаалтын зардлын төсвийг дутуу олгож ирсэнтэй холбоотой Өлгий сумын ЕБ-ын 1-р сургууль 22.6 сая, 6-р сургууль 4.8 сая, лаборатор 2-р сургууль 69.8 сая, 3-р сургууль 94.9 сая, Сагсай сумын Хүүхдийн 3-р цэцэрлэг 3.1 сая, аймгийн Музей 10.2 сая, Биеийн тамир спортын газар 39.6 сая, Хөгжимт драмын театр 54.3 сая, нийтдээ 299.3 сая төгрөгийн түлш халаалтын өглөг шинээр нэмэгдсэн байна.
- Он дамжсан түлш халаалтын өглөгийг Дэлүүн сумын ЕБ-ын 1-р сургууль 21.4 сая, Улаанхус сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль 3.5 сая төгрөг, Сагсай сумын Хүүхдийн 2-р цэцэрлэг 1.2 сая, нийт 26.1 сая төгрөгөөр бууруулсан байна. Өлгий сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 31.0 сая төгрөгийн он дамжсан түлш халаалтын өглөг барагдаагүй байна.
- Алтай сумын ЕБ-ын сургууль 0.6 сая, Бугат сумын ЕБ-ын сургууль 2.6 сая, Толбо сумын ЕБ-ын сургууль 2.6 сая, Өлгий сумын 10 дугаар сургууль 11.8 сая, Бугат сумын хүүхдийн 2-р цэцэрлэг 0.7 сая, Өлгий сумын 12-р цэцэрлэг 0.3 сая, 16-р цэцэрлэг 0.2 сая төгрөгөөр, Булган сумын ЗДТГ 5.7 сая, Улаанхус сумын ИТХ 3.8 сая, Цагааннуур тосгоны Захирагчийн алба 6.3 сая, Өлгий сумын ИТХ 5.2 сая, Асрамжийн газар 2.1 сая, Хот тохижуулах алба 10.5 сая төгрөгийн цалин хөлс, бараа үйлчилгээний зардлын өглөгийг шинээр үүсгэсэн байна.

### **Урт хугацаат өр төлбөр**

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд нийтдээ 3127.6 сая төгрөгийн урт хугацаат өр бүртгэлтэй байна.

“Суат” ХХК-д Азийн Хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр “Орон нутгийн хотуудын Нийтийн аж ахуйг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд аймгийн төвийн цэвэр бохир усны системийн техник, технологийг шинэчлэх цэвэр усны шугам хоолойг өргөтгөх, цэвэр бохир усны насосын станц, 30 хүний халуун усны барилгад их засвар, 3 ба 5 хүний халуун ус барих, ус түгээх, 2 ш гүний худаг барих, машин техник нийлүүлэх, цэвэрлэх байгууламжид био цөөрмийн карт барих зэрэг ажлуудад 2002 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 991.0 сая төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Цахилгаан шугам сүлжээний газарт Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн “Цахилгааны шугамын шинэчлэл, алдагдал бууруулах” төслөөр 2009 онд хийгдсэн урт хугацаат хөрөнгө оруулалтын 2136.6 сая төгрөгийн зээл бүртгэлтэй байна.

Дээрх төсөл хэрэгжсэн аж ахуйн нэгжүүдийн урт хугацаат хөрөнгө оруулалтын зээл нь барагдаагүй байна.

“Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд Өлгий сумын Сум хөгжүүлэх сангаас авсан 20.0 сая төгрөгийн он дамжсан зээл барагдаагүй байна.

“Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын богино хугацаат өглөгийн үлдэгдэл **102.2** сая төгрөгийн, Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл **266.1** сая төгрөг /аймгийн ОНХСангаас 2014 онд олгосон 200.0 сая төгрөгийн зээл, иргэдээс урьдчилж авсан түрээсийн төлбөрийн 66.0 сая төгрөгийн өглөг/-ийн, Урт хугацаат өр төлбөрийн хувь хүмүүсийн зээлийн эхний үлдэгдлээс **138.0** сая төгрөг /иргэдээс павильоны анхны тавилтын үнийн урьдчилгаанд авсан/-ийн өр төлбөрийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдлээр тайлагнасан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 59 дүгээр тогтоолоор “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан байна. Дээрх тогтоолтой холбоотой аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 112 дугаар тогтоолоор 2013 онд баригдсан 3052.0 сая төгрөгийн Битүү захын 60 хувь буюу 1831.5 сая төгрөгийн барилга, 26.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4400 мкв эзэмшил газрын хамт аймгийн Орон нутгийн өмчийн газрын балансад шилжүүлсэн байна.

Харин дээрх урт болон богино хугацаат нийт 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэж тайлагнах, барагдуулах талаар тодорхой шийдвэр гараагүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өглөгийн данстай холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:*

- Алтай сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 0.7 сая төгрөгийн, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль 2.7 сая төгрөгийн, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 1.4 сая төгрөгийн цалингийн татварыг дутуу төлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй.
- Дэлүүн сумын Эрүүл мэндийн төв 17.0 сая төгрөгийн, Бугат сумын Эрүүл мэндийн төв 2.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Өлгий сумын ИТХурал 6.3 сая төгрөгийн, ЗДТГазар 5.6 сая төгрөгийн, Цагааннуур тосгоны ЭМТөв 19.1 сая төгрөгийн, Сагсай сумын 3 дугаар цэцэрлэг 3.1 сая төгрөгийн, Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэг 2.1 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн, Сагсай сумын 1 дүгээр цэцэрлэг он дамжсан өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй.
- Өлгий сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль халаалтын тооцоогоор үүссэн 67.1 сая төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулаагүй байна.

**3.5.9 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 180419.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 210912.0 сая төгрөг болж, оны эхнээс 30494.1 сая төгрөгөөр өссөн байна.

<i>Хүснэгт №08 Засгийн газрын хувь оролцооны үлдэгдэл</i>			<i>/сая төгрөг/</i>
<i>Үзүүлэлт</i>	<i>Эхний үлдэгдэл</i>	<i>Эцсийн үлдэгдэл</i>	<i>Өсөлт/+, бууралт /-/</i>
Засгийн газрын оруулсан капитал	<b>69,595.70</b>	<b>69,733.70</b>	138.00
Өмч: -төрийн	69,595.70	69,733.70	138.00
- хувийн			-
- хувьцаат			-
Хуримтлагдсан үр дүн	<b>41,712.30</b>	<b>70,580.30</b>	28,868.00
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	<b>69,109.90</b>	<b>70,598.00</b>	1488.10
<b>Дүн</b>	<b>180,417.90</b>	<b>210,912.00</b>	<b>30,494.10</b>

<b>Үүнээс төрлөөр</b>			
Төсөвт байгууллага, төсөл сан	162,469.30	193,837.90	31,368.60
ТӨҮГ болон ОНӨҮГ	17,948.60	17,074.10	-874.50
<b>Дүн</b>	<b>180,417.90</b>	<b>210,912.00</b>	<b>30,494.10</b>

*Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант оны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний данс нь 1488.1 сая төгрөгөөр, Засгийн газрын оруулсан капитал данс 138.0 сая төгрөгөөр өсч, хуримтлагдсан үр дүн тайлант оны үр дүн 28868.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

*Аудитаар Засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.*

### 3.5.10. Орлогын данс

Аймгийн Төсвийн ерөнхий захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар тайлант онд орон нутгийн орлогоос 13316.5 сая төгрөгийн орлого оруулж, Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс 82025.8 сая төгрөгийн, хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 9890.0 сая төгрөгийн, аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогоос 2281.8 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 2730.9 сая төгрөгийн, нэмэлт санхүүжилтээр 3091.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 1146.3 сая төгрөг оруулан, үнэ төлбөргүйгээр 32026.0 сая төгрөгийн хөрөнгө, бараа материалыг хүлээн авч, нийтдээ 146508.6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтонд цалингийн татварын орлогоос 868.0 сая төгрөг олгосон байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт орлого 146508.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 21698.6 сая төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг, нэмэлт санхүүжилт, ЭМД-ын сангийн санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын санхүүжилт бүгд нэмэгдсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ТЕЗ-ийн тайлангаар үндсэн болон туслах үйл ажиллагааны орлоготой холбоотой алдаа зөрчил гараагүй байна.*

### 3.5.11 Зардлын данс

Төсвийн ерөнхий захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт зардал 104827.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 3403.7 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Нийт зардлын 96.1 хувь нь бараа үйлчилгээний зардал, 3.9 хувь нь хувийн хэвшлийн байгууллагын татаас, урсгал шилжүүлэг зардлууд байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, НДШ, тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, эд хогшлын зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд хувийн хэвшлийн байгууллагын санхүүжилтийн зардлууд 81.3-4823.8 сая төгрөгөөр өссөн, нормативт зардал, урсгал шилжүүлэг 1271.7-3371.6 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны орлого, зарлагаас ихээхэн хэмжээний өөрчлөлт нь тайлант онд Дэлүүн, Ногооннуур, Цэнгэл сумдын Эрүүл мэндийн төвүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зардлын данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

**Аудитын илрүүлэлт:**

*ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:*

Орон нутгийн 37 төсвийн байгууллагуудаас байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, худалдан авсан бараа материалын тооцоог өглөгийн дансанд бүртгэж, тооцоо үүсгэхгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 792.0 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өгөгдлөө.

Сагсай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль нормативт зардлын гүйцэтгэлд хүүхэд-өдрөөр хяналт тавьж, хэмнэгдсэн төсвийг төсөвт төвлөрүүлж ажиллаагүйгээс оны эцэст үдийн хоолны зардлын төсвөөс 22.7 сая төгрөгийн хүнсний зүйл нөөцөлж төсвийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдож төсөвт нөхөн төлүүлэх акт тогтоосон.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үзэхэд тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй 56 байгууллага, 1.2 дахь заалтыг хэрэгжүүлээгүй 5 байгууллага, 1.4 дэх заалтыг хэрэгжүүлээгүй 8 байгууллагад нийтдээ 410.2 сая төгрөгийн зөрчилд Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн төсвийн 9 байгууллага шүүхийн шийдвэрийн дагуу 10 ажилтанд ажлаас үндэслэлгүй халагдаж ажилгүй байсан хугацааны цалинд 80.2 сая төгрөг төлж, төсвөөс үр ашиггүй зардал гаргасан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 24 хөтөлбөрт зориулан 97,715.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 89,199.6 сая төгрөгийг урсгал зардалд, 8,516.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Нийт зардлын 67,213.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 18,660.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 8,360.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 513.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,425.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 1,542.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс төвлөрүүлэг шилжүүлгийг хассан дүнгээр нийтдээ 66,926.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 19,603.4 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 8,360.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 419.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,394.3 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 31.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс авсан нийт санхүүжилтээс 287.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аймгийн 2021 оны оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээр нийтдээ 95.523.5 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж, төлөвлөснөөс 2,192.3 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Орон нутгийн төсөв болон урьд оны үлдэгдлээс 13,751.2 сая төгрөгийн санхүүжилт, 6,451.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас 13,151.6 сая төгрөгийн санхүүжилт, 6,451.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч 19,603.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд Орон нутгийн хөгжлийн сангуудад 523.6 сая төгрөгийн урьд оны үлдэгдлээс баталсан хөрөнгөөс зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарч, төсөвт байгууллагууд 76.0 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 513.0 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж ажиллахаас 419.4 сая төгрөгийн санхүүжилт авч 93.6 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 1418.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн ба үүнээс 88.0 сая төгрөг нь орон нутгийн татварын бус орлогын төсөвт байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, 3.5 сая төгрөг нь Ногооннуур сумын Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл, 1,319.1 сая төгрөг нь сумуудын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлсэн орлого, 7.4 сая төгрөг нь Байгаль хамгаалах сангуудын үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн байна. Туслах үйл ажиллагааны орлогоос 29.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95,523.5 сая төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилттэй холбоотой байна.

Аймгийн Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэлийн 88.6 хувийг бараа үйлчилгээний зардал, 2 хувийг урсгал шилжүүлэг, 7.9 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын 62.7 хувийг цалингийн, 8.3 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 5.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 1.4 хувийг хангамжийн зардал, 3.4 хувийг нормативт зардал, 18.4 хувийг бусад зардлууд эзэлж байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 137.6 сая, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 42.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2365.8 сая төгрөгийн, нийтдээ 3091.3 сая төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс, НДШ-тэй холбоотой зардалд 687.1 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал зардалд 39.7 сая, хангамж, бараа материалын зардалд 173.0 сая, нормативт зардалд 253.2 сая, эд хогшил, урсгал засварын зардал 63.8 сая, томилот, зочны зардалд 16.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжинд 22.2 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 1029.9 сая, урсгал шилжүүлгийн зардалд 569.1 сая, хөрөнгийн зардалд 172.8 сая төгрөгийг, нийтдээ 3027.2 сая төгрөгийг зарцуулж, 72.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд 79 мэдээллийг ил тод байршуулахаас 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Бүтэн жилийн мэдээллээс аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 мэдээлэл, сар бүр оруулах мэдээллээс төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 18 мэдээлэл, нийт 19 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Аудитын дүнгээр Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллүүдийг хугацаандаа бүрэн оруулах, зөрчлийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгөгдлөө.

#### *Аудитын илрүүлэлт:*

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой нийтдээ 27707.1 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгөгдлөө. Үүнд:*

*Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн данстай холбоотой нийтдээ 10991.7 сая төгрөгийн зөрчил илэрч 9386.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1604.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.*

*Орон нутгийн өмчийн 2 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн данстай холбоотой 5664.8 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөн.*

*Төсвийн төвлөрүүлэн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 8 сумаас шилэн данстай холбоотой 11050.6 сая төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага өгөгдлөө.*

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчид 2 заалттай зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилтийг давтан шалгаж үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудын өр, авлагын барагдалт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналт, түүний үр дүнг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна. Энэхүү асуудал нь анхаарал татахуйц чухал асуудал байгаа болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 2377.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2377.1 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгаж ажиллах талаар 2 заалттай зөвлөмж өгөв.

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар дүгнэж гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 188 төсвийн байгууллага нэгж, 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 14 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 205 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 205 байгууллага, нэгж аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 122 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, сумын ИТХ, Соёлын төв, Өлгий сумын хүүхдийн цэцэрлэгүүд, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан зэрэг 83 байгууллага, нэгжийн санхүүгийн тайланг түүвэрт хамрууллаа. Үүнд:

Нийт 107 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 14 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалтай”, 1 байгууллагын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт дүгнэлт өгөв. Санхүүгийн тайлангаар “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгөөгүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийтдээ 37,701.8 сая

төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 2,979.9 сая төгрөгийн алдааг залруулж, 72.8 сая төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 31,886.5 сая төгрөгийн зөрчилд 152 албан шаардлага, 12 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 2762.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 90 зөвлөмж өгөгдсөн байна. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал гараагүй байна.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга:**

Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайланг э-тайлантай тулгалт хийхэд 1276.8 сая төгрөгийн орлогын, 14.4 сая төгрөгийн зардлын, дансны үлдэгдэлтэй холбоотой 1189.5 сая төгрөгийн, нийтдээ 2377.1 сая төгрөгийн алдааг залруулав.

#### **Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:**

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар акт тогтоогдоогүй, албан шаардлага өгөгдөөгүй байна.

#### **Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсвийн 188 байгууллагаас 105 байгууллагад бие даасан дүгнэлт гаргаж, 83 санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Үүнээс 90 байгууллагад “Зөрчилгүй”, 14 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Алтай сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Бугат сумын ЕБ-ын сургууль, Дэлүүн сумын ЕБ-ын 2-р сургууль, Улаанхус сумын ЕБ-ын 2 дугаар сургууль, Баяннуур, Толбо сумын цэцэрлэг, Ногооннуур сумын 2 дугаар цэцэрлэг, Улаанхус сумын Хөххөтөл цэцэрлэг, Бугат, Дэлүүн сум, Цагааннуур тосгоны ЭМТөв, Алтай, Булган, Өлгий сумын Засаг даргын тамгын газар зэрэг 14 байгууллагын санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, Сагсай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд “сөрөг” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 18,846.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 932.0 сая төгрөгийн алдааг залруулж, 72.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15,171.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2671.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 78 зөвлөмж өгч, 12 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэв.

#### **Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар**

Орон нутгийн өмчийн 3 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5757.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч үүнээс 0.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5664.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 91.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн байна.

#### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 14 сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 14 сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 13098.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2047.9 сая төгрөгийн алдааг залруулж, 11050.6 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага, 9 алдаа зөрчилд 9 заалттай зөвлөмж өглөө.

Хүснэгт 11: Харьяа байгууллагуудаас илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэсэн судалгаа

/сая төгрөгөөр/

№	Аудитын нэр	Илрүүлэлт						Запуулсан алдаа	Запуулагдаагүй алдаа, зөрчлийн дүн	Запуулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
		Зөрчил		Алдаа		Бүгд				Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	259	17,914.30	35	932.00	294	18,846.30	35	932.0	259	17914.3	27	72.0	142	15,171.2	78	2,671.1	12	-
2	ОНӨААН	4	5,757.00	-	-	4	5,757.00	-	-	4	5757.00	1	0.8	2	5,664.7	1	91.5	-	-
3	ТТЗ	17	11,050.60	12	2,047.90	29	13,098.50	12	2,047.9	17	11050.6	-	-	8	11,050.6	9	-	-	-
	<b>Дүн</b>	<b>280</b>	<b>34,721.90</b>	<b>47</b>	<b>2,979.90</b>	<b>327</b>	<b>37,701.80</b>	<b>47</b>	<b>2,979.9</b>	<b>280</b>	<b>34,721.90</b>	<b>28</b>	<b>72.8</b>	<b>152</b>	<b>31,886.5</b>	<b>90</b>	<b>2,762.6</b>	<b>12</b>	<b>-</b>

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь аймгийн ТЕЗ-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно. Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**1. Шилэн данстай холбоотой асуудал:**

**1.1. Илрүүлэлт:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2021 онд 79 мэдээллийг ил тод байршуулахаас 58 мэдээллийг хугацаандаа байршуулж, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Бүтэн жилийн мэдээллээс аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 мэдээлэл, сар бүр оруулах мэдээллээс төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл зэрэг 18 мэдээлэл, нийт 19 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан журмыг мөрдөж аймгийн ТЕЗ-ийн шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

## 2. Балансын данстай холбоотой асуудал

### 2.1. Илрүүлэлт:

“Жана-Өлке” ОНӨААТҮГазар татан буугдсантай холбоотой богино хугацаат өглөгийн үлдэгдэл 102.2 сая төгрөгийн, Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 266.1 сая төгрөгийн, Урт хугацаат өр төлбөрийн хувь хүмүүсийн зээлийн эхний үлдэгдлээс 138.0 сая төгрөгийн нийт 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үлдэгдлээр тайлагнасан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 59 дүгээр тогтоолоор “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ыг татан буулгасан байна. Дээрх тогтоолтой холбоотой аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 112 дугаар тогтоолоор 2013 онд баригдсан 3052.0 сая төгрөгийн Битүү захын 60 хувь буюу 1831.5 сая төгрөгийн барилга, 26.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4400 кв м эзэмшил газрыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын өмчид шилжүүлжээ.

Харин дээрх урт болон богино хугацаат нийт 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэж тайлагнах, барагдуулах талаар тодорхой шийдвэр гараагүй байна.

### 2.2. Өгсөн зөвлөмж:

“Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын нэр дээр бүртгэлтэй байгаа 506.3 сая төгрөгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэж тайлагнах, барагдуулах талаар тодорхой шийдвэр гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн СНТайлан	13	2377.1	12	2377.1					1	
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:</b>											
1	Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн СНТайлан	1								1	
	<b>Дүн</b>	<b>14</b>	<b>2377.1</b>	<b>12</b>	<b>2377.1</b>					<b>2</b>	



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/05

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2018 оны А/207 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх" тушаалын 5 дугаар хавсралтын 2.1, 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын хоёрдугаар газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

Гурав. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Т.Фестивал/ нарт зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг 2022 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг санхүүгийн тайлангийн аудит хариуцсан ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



D:\bichig hereg\2022\tushaal.doc